

2008.06.12

Дугаар 138

“БиДиСек” ХК-ийн нэмж гаргаж
буй хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7 дахь заалт, “БиДиСек” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1.“БиДиСек” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 000 000 ширхэг нэмж гаргаж буй энгийн хувьцааг үнэт цаасны зах зээлд арилжаалахаар зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл, Хөрөнгийн биржийн бүртгэл, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2.Нэмж гаргаж байгаа хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэх болон нийтэд санал болгох үнийг тухайн үеийн арилжааны дундаж ханшаас хамааруулан ТУЗ-ийн хурлаар дахин хэлэлцэж тогтоон, Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авахыг “БиДиСек” ХК /Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.

3.Нэмж гаргаж байгаа хувьцаанаас хувь тэнцүүлсэн байдлаар тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэх өдрийг 2008 оны 6 дугаар сарын 12-ны өдрөөр тогтоохыг “БиДиСек” ХК-ийн ТУЗ-д зөвлөсүгэй.

4.Энэ тогтоолын хавсралтаар баталсан товч танилцуулгын дагуу үнэт цаасыг нийтэд сурталчлан, олон нийтийг бодитой мэдээллээр хангах, Хорооноос зөвшөөрсөн үед арилжааг эхлүүлэх, үнэт цаасны арилжааны тайланг хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг ханган, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “БиДиСек” ХК /Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.

5.Хорооны 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 210 дугаар тогтоолоор баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т заасан дотоод журмуудыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг “БиДиСек” ХК /Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.

6.Энэхүү тогтоол болон хавсралтыг ажлын 3 хоногийн дотор Хорооны веб хуудсанд байршуулахыг Тамгын газар /Н.Удаанжргал/, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ

“БИДИСЕК” ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ТАНИЛЦУУЛГА

Танилцуулгын эхний хэсэг

1. Үнэт цаас гаргагчийн түүх, үйл ажиллагааны төрөл, хэтийн төлөв, үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн чиглэл, тухайн зах зээлд үнэт цаас гаргагчийн эзлэх байр суурийн талаархи мэдээлэл, судалгаа:

- БидиСек” ХК нь хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж эхлээд 17 жил болж буй тус зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага.
- 2006 онд олон нийтэд өөрийн хувьцааг санал болгон арилжаалан хөрөнгийн зах зээл дээрээс 1 тэрбум төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлж үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөн ажиллаж, өнгөрсөн жилүүдэд хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ сайн биелүүлж, 2007 оны хөрөнгийн зах зээлийн “Шилдэг хувьцаат компани”-аар тодорсон.
- Өнгөрөгч 2007 онд тус компанийн татварын дараах цэвэр ашиг 990 сая төгрөгт хүрч өмнөх оноос 20,9 дахин өссөн байгаа.
- Компани 2006 онд олон нийтэд хувьцаагаа гарган хөрөнгө татан төвлөрүүлснээс хойш үйл ажиллагааны ашгаас 2006 онд нэгж хувьцаанд 3 MNT, 2007 онд нэгж хувьцаанд 30 MNT-ийн ноогдол ашиг тарааж байна.

“БидиСек” ХК – Тусгай Зөвшөөрлүүд

- 1996 оноос Брокер, дилер
- 2005 оноос Андеррайтинг
- 2006 оноос Нээлттэй Хувьцаат компани болсон
- 2007 оноос Хөрөнгө оруулалтын зөвлөх

Андеррайтерын үйл ажиллагаа

“БидиСек” ХК нь Монголын хөрөнгийн зах зээлд андеррайтерын үйлчилгээг гүйцэтгэхдээ компанийн “Андеррайтерын үйлчилгээний дотоод журам”-ын дагуу төслүүдийг хүлээн авч журамд заасан тоон болон тоон бус шалгуур үзүүлэлтүүдийн дагуу төсөл хэрэгжүүлэгч компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулан хамтран ажилладаг. Бид:

- ✓ 2005 онд нийт 6 төсөл хүлээн авч 1 компанийн бонд гаргаж олон нийтэд арилжаалсан.
- ✓ 2006 онд нийт 15 төсөл хүлээн авч 2 компанийн хувьцаа, 1 компанийн бонд гаргасан.


- ✓ 2007 онд нийт 23 төсөл хүлээн авч 3 компанийн хувьцаа, 1 компанийн бонд гаргаж мөн 4 компанид хувийн хөрөнгө оруулалт хийн ажиллаж байна.
- ✓ 2008 оны байдлаар нийт 16 төсөл хүлээн аваад байгаа бөгөөд эдгээрийн 2 компанигай нь хувьцаа гаргахаар ажиллаж байна.

"БиДиСек" ХК-ийн Андеррайтинг хийсэн хувьцаанууд

Компанийн нэр	Хувьцааны тоо	IPО зах зээлд арилжаалагдсан үнэ	Хаалтын ханш /2008.05.13/	Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө
Монгол шилтгээн	1`000`000	800	1`200	800`000`000
Женко Тур Бюро	70`000`000	100	245	8`500`000`000
Хай Би Ойл	4`000`000	100	350	400 000 000
	2`000`000	300	350	600`000`000
Монинжбар	10`000`000	100	250	1 000`000`000
Туул Сонгино Усны нөөц	13`200`000	1000	1`100	13`200`000`000

Харилцагчид


Харилцагчдын өсөлт




харилцагчдын тоо нэмэгдсэн. 2006-2007 онд "Женко Тур Бюро" ХК-ийн "50`000 бяцхан хувьцаа эзэмшигч хөтөлбөр"-ийг амжилттай хэрэгжүүлснээр нийт харилцагчдын тоо 140%-аар өссөн.

- ✓ Нийт харилцагчдын 45%-ийн УБ хотын харилцагчид, 17%-ийг Төв аймгийн үндсэн харилцагчид, 0,2%-ийг гадаад харилцагчид, 37,8%-ийг бусад аймгийн харилцагчид эзэлдэг.
- ✓ Монголын хөрөнгийн зах зээлд оролцдог гадаад харилцагчдын 80%, томоохон байгууллагуудын 60% нь "БиДиСек" ХК-аар үйлчлүүлж байна.


Зах зээлийн үнэлгээ



Хувьцааны арилжааны хэмжээ



2. Үнэт цаас гаргагчийн зохион байгуулалт, удирдлагын бүтэц, салбар төлөөлөгчийн газрууд, нэгжийн тухай танилцуулга:



"БидиСек" ХК нь Төв аймгийн үндсэн харилцагчдыг хариуцан ажилладаг бөгөөд Төв аймгийн Зуунмод хотод 2006 оны 1-р сараас өөрийн салбарыг нээн ажиллуулж байна.

Салбар нь Төв аймгийн нийт 10,000 гаруй харилцагчдад долоо хоногийн даваа, пүрэв гаригуудад очин брокерын үйлчилгээ үзүүлж байгаа.

Салбарын хаяг:

Төв аймаг, Зуунмод хот, Монгол даатгалын байр 202 тоот

3. Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар:

"БидиСек" хувьцаат компанийн дүрмийн хуулбарыг хавсаргав.

4. Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах тухай үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллагын шийдвэр. Хэрэв уг үнэт цаасыг гаргах нь тухайн компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдохоор бол шийдвэрийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу гаргасан тухай мэдээлэл:

"БидиСек" ХК -ийн Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын 2008 оны 2 сарын 27 ны өдрийн 8-т тогтоолыг үндэслэв.

5. Сангийн сайдын 2004 оны 12 сарын 22-ны өдрийн 248 тоот тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлан, түүний тодруулга бэлтгэх заавар", Хорооноос баталсан "Үнэт цаас гаргагч, зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын тайланд нэмэлт тодруулга бэлтгэх журам"-д заасан нэмэлт тайлбар тодруулгыг бүрэн тусгасан сүүлийн 3 жилийн болон үнэт цаасыг бүртгүүлэхээр зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахын өмнөх улиралын аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан:

"БидиСек" ХК-ийн 2005, 2006, 2007, онуудын жилийн эцэсийн 2008 оны 1-р улирлын аудитын байгууллагаар баталгаажсан тайлангуудыг хавсаргав.

6. Үнэт цаас гаргагч компани болон түүний толгой, охин компани болон хяналтын багцыг эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд нь хугацаа хэтэрсэн зээлийн өргүй болох талаар банкны өр барагдуулах алба, харилцагч банкны тодорхойлолт:

Банкны өр төлбөр барагдуулах төвөөс авсан "БиДиСек" ХК-ийн өр төлбөрийн тодорхойлолт болон компанийн удирдлагын өр төлбөрийн тодорхойлолтыг хавсаргав.

7. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэн баталгаажуулсан материал:

"Нимм аудит" ХХК.
БЗД, 3 хороо, 12 хороолол, "Нимм аудит" ХХК-ийн байр, Утас 463301
"БиДиСек" ХК-ийн бизнесийн үнэлгээний тайланг хавсаргав.

8. Хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэх зөвшөөрлийн хураамж төлсөн баримт:

Хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэх зөвшөөрлийн хураамжийг төлсөн баримтыг хавсаргав.

Танилцуулгын хоёрдахь хэсэг

1. Үнэт цаасны төрөл, хэлбэр:

- a. Үнэт цаасны төрөл: Энгийн хувьцаа
- b. Үнэт цаасны хэлбэр: Биет бус

2. Үнэт цаас эзэмшигчийн эрх:

МХБ-ээр дамжуулан энгийн хувьцааг худалдан авч өмчилсөн байгууллага, иргэн нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 1) Хувьцаагаа хоёрдогч зах зээл дээр худалдах;
- 2) Хувьцаагаа барьцаалах, бэлэглэх;
- 3) Компанийн энгийн хувьцааг худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувь нийлүүлэгч болно.
- 4) Компанийн хувь нийлүүлэгчдийн хурал зарлах үед Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон "бүртгэх өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй.
- 5) Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах.
- 6) Компанийг татан буулгах үед "Компанийн тухай" хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх эрхтэй.
- 7) Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

- 8) Хувь нийлүүлэгчдийн хурлаас доорхи асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компани эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
- a. Нийтлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож өөрчлөх;
 - b. Хэлцэл хийхийн өмнө сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн;
 - c. Компанийн хувь нийлүүлэгчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг Компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай Компанийн дүрмийг шинэчилсэн найруулгыг баталсан;
 - d. Нэг хувь нийлүүлэгч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
 - e. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 хоног ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.
 - f. Хувь нийлүүлэгч нь “Компанийн тухай” хуулийн 66.4-т заасан мэдээлэлтэй танилцах эрхтэй.

3. Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр, график:

- a. “БиДиСек” ХК-ийн энгийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээл дээр арилжаалахдаа МХБ болон ҮЦТТХТ ХХК-тай хийсэн гэрээний дагуу үнэт цаасыг биет бус хэлбэрээр хадгалах бөгөөд эхний нийлүүлэлтийг ҮЦТТХТ ХХК-ийн 07-999998 данснаас 900 000 ширхэгийг 3000 төгрөгийн үнэтэйгээр нийлүүлнэ.
Давуу эрхээр хувьцаа эзэмших хувьцаа эзэмшигчдийн хувьцааг арилжааны эхний өдрийн арилжаанаас өмнөх 10 минутанд байршуулах бөгөөд үлдсэн захиалыг үнийн ахлах дарааллаар гүйцэтгэнэ.
- b. Үнэт цаасны арилжааны мэдээг Монголын хөрөнгийн биржийн (www.mse.mn) веб сайт, БиДиСек ХК-ийн (www.bdsec.mn) вэб сайт болон өөрийн харьяа брокер, дилерийн компаниудаас авч болно.

4. Урьд үнэт цаас гаргаж байсан эсэх, үнэт цаасны нэр төрөл, гаргасан огноо, нийт хэмжээ, төлөгдөх буюу төлөгдсөн хэмжээ, өрийн бичиг гаргасан бол үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь барагдуулж байсан тухай үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагын тодорхойлолт:

- a. *“БиДиСек” ХК нь 2006.06.23-ны өдөр өөрийн компанийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 10 000 000 ширхэг энгийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгон арилжаалж нээлттэй хувьцаат компани болсон.*

5. Үнэт цаас гаргах замаар хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах төсөл, эдийн засгийн үр ашгийн тооцоо:

- a. 1,250,000,000 төгрөгийг компани өөрийн байртай болох зорилгоор үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийнэ.
- b. Тус байрны нийт өртөг нь 1,950,000,000 төгрөг бөгөөд үүнээс одоогийн байдлаар 700,000,000 төгрөгийн төлбөрийг 2007 оны ашгаас төлсөн байгаа.
- c. 250,000,000 төгрөгийг байрны засвар тохижуулалт, техник технологийн шинэчлэлд
- d. 1,500,000,000 төгрөгийг хөрөнгө оруулалт нэмэгдүүлэхэд
- e. 2008-2013 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хавсаргав.

6. Үнэт цаасыг арилжаалахад санал болгох хүрээ:

- a. *КТХ-ийн 39-р зүйлийн дагуу компанийн хуучин хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг олгон санал болгоно.*
- b. *Үлдэх хэсгийг олон нийтэд санал болгоно.*

7. Тухайн үнэт цаасыг худалдан авснаар хөрөнгө оруулагчид учирч болох эрсдэл, эрсдлийн шинжилгээ:

БиДиСек ХК-ийн энгийн хувьцааг худалдаж авснаар хөрөнгө оруулагчид дараах зүйлүүд дээр анхаарч үзнэ үү.

Доор дурдсан эрсдлийн хүчин зүйлүүдээс хамааран компани төлөвлөсөн үр дүндээ хүрэхгүй байх магадлалтай. Эдгээрт:

- i. *Монгол улсын эдийн засаг, Хөрөнгийн зах зээл, улс төрийн тогтворгүй байдал*
- ii. *Хууль эрх зүйн орчны өөрчлөлтүүд*

Ирээдүйн орлогод нөлөөлөх эрсдлийг “БиДиСек” ХК эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэн хэрэгжүүлж түүнээс зайлсхийх эсвэл багасгаж чадах ч компанийн үйл ажиллагаанаас үл хамааран учрах эрсдлийн хүчин зүйлүүдээс 100 хувь зайлсхийж чадахгүй.

8. Үнэт цаасыг андеррайтераар дамжуулан анхдагч зах зээлд худалдахаар төлөвлөж байгаа бол байгуулах гэрээний төсөл, өөрөө анхдагч зах зээлд худалдах бол мэдээллийг нийтэд сурталчлах журам, төлөвлөгөө:

- a. *“БиДиСек” ХК нь андеррайтерын үйчилгээ үзүүлдэг компани тул өөрийн компанийн хувьцааг зах зээлд компани өөрөө зуучлан гаргана.*

б. Мэдээллийг олон нийтэд хүргэх сурталчилах журам боловсруулан батлаж хавсаргасан.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7.3, 7.4-Д ЗААСАН МЭДЭЭЛЭЛ

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг:

“БиДиСек” ХК, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Залуучуудын өргөн чөлөө 27/1 байр
Утас: 976-11-321763
Факс: 976-11-323411
Имайл: info@bdsec.mn

2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар:

Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргав.

3. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5-аас дээш хувийг эзэмшдэг этгээдийн талаарх мэдээлэл:

#	Овог Нэр	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны %
1	Д.Даянбилгүүн	Гүйцэтгэх захирал	31,17%
2	Zwahr Alexander	Хөрөнгө оруулагч	30,5%
3	Firebird Global Master Fund 1	Хөрөнгө оруулагч	10,0%
4	Firebird Global Master Fund 2	Хөрөнгө оруулагч	10,0%

4. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь уг үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг эзэмшдэг бол түүний хувь хэмжээ:

#	Овог Нэр	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны %
1	Д.Даянбилгүүн	Гүйцэтгэх захирал	31,17%
2	Б.Лхагвадорж	Дэд захирал	4,66%

5. Үнэт цаас гаргагчийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан санхүүгийн тайлан, өр, зээлийн талаархи мэдээ:

Санхүүгийн үйл ажиллагаа


	2006	2007	Өсөлтийн хувь
Хөрөнгө	1 085 130 218,75	2 111 106	

		932,60	94,55
Эргэлтийн хөрөнгө	1 019 446 084,27	1 483 305 432,65	45,50
Үндсэн хөрөнгө	65 684 134,48	627 801 499,95	855,79

Хөрөнгийн харьцаа 2007 он



Хөрөнгийн өсөлт





	2005	2006	2007
Өр төлбөр	22 016 196,93	25 381 600,00	92 739 752,11
Хөрөнгө	284 520 531,41	1 085 130 218,75	2 111 106 932,60
Эзэмшигчдийн өмч	262 504 334,82	1 059 748 618,75	2 018 367 180,49
Нийт хөрөнгөд эзлэх өр төлбөрийн дүн	7%	1,8%	4%
Эзэмшигчдийн өмчид эзлэх өр төлбөрийн дүн	8%	2%	5%


Компанийн нийт хөрөнгө ба эзэмшигчдийн өмчийн дүнд эзлэж буй өр төлбөрийн дүн сүүлийн гурван жилд тогтвортой 10-аас доош хувь байгаа нь компанийн өр төлбөрийн харьцаа байж болох зохистой төвшинд байгааг илэрхийлж байна.

	2006	2007	Өсөлтийн хувь
Үндсэн Үйл ажиллагааны орлого	173 278 831,57	2 019 773 735,11	1 065,62
Татварын өмнөх ашиг	57 309 683,93	1 103 117 137,44	1 824,84
Татвар	10 065 500,00	112 609 686,70	1 018,77
Татварын дараах ашиг	47 244 183,93	990 507 450,74	1 996,57

Нэгж хувьцаанд ноогдох ашиг	4,72	99,05	1 996,57
Ноогдол ашиг	3	30	900



Татварын өмнөх ашгийн хэмжээгээр



6. Үнэт цаасыг арилжаалахад зуучлах мэргэжлийн байгууллагын тухай мэдээлэл:

Тухайн үнэт цаасыг “БиДиСек” ХК өөрөө зуучлан гаргана.

7. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл:

Үнэт цаас гаргагч нь өөрийн оффисын байртай болох зорилгоор үл хөдлөх хөрөнгө худалдан авах гэрээ байгуулсан. Тус гэрээний хуулбарыг хавсаргав.